

Хүндэт АУС-ийн багш ажилтан болон сурагчдын гэр бүлийнхэн:

Сургуулийн Удирдах Зөвлөлөөс шинэ Ерөнхий зохицуулагчийг (superintendent) сонгон томилох үйл явцыг эхлүүлснийг та мэдэж байж магадгүй. Энэхүү чухал үйл явцад бид Ерөнхий зохицуулагчийг хайн олох чиглэлээр мэргэшсэн, үндэсний рекрутмент компани болох BWP & Associates (BWP)-ийн үйлчилгээг авч байгаа юм.

Энэхүү үйл явцын нэг чухал хэсэг бол сурагч, багш ажилтан, гэр бүл, иргэдтэй ярилцаж, шинэ Ерөнхий зохицуулагчаас бидний хүсэн хүлээж буй зан байдлыг тодорхойлж, тус албан тушаалын чиг үүргийг боловсруулах ажил юм. BWP компани Сургуулийн Удирдах Зөвлөлтэй хамтран ажиллаж, хэд хэдэн тусгайлсан бүлгийн болон иргэдийн санал бодлыг авч, мөн судалгаа явуулах юм.

Сургуулийн Удирдах Зөвлөл манай бүх иргэдийг BWP компанийн зөвлөхүүдийн зохион байгуулах үүлзалтад оролцохыг урьж байна. Таныг 1-р сарын 22 эсвэл 1-р сарын 25-нд олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэгт оролцоно гэж бид найдаж байна.

- **1-р сарын 22-ны Лхагва гарагийн 19.00 цагт (Испани хэлээр)**
Kenmore дунд сургууль дээр, 200 S. Carlin Springs Road
- **1-р сарын 22-ны Лхагва гарагийн 19.00 цагт**
Washington-Liberty ахлах сургууль дээр, 1301 N. Stafford Street
- **1-р сарын 25-ны Бямба гарагийн 10 цагт**
Wakefield ахлах сургууль дээр, 1325 S. Dinwiddie Street
- **1-р сарын 25-ны Бямба гарагийн 10 цагт**
Dorothy Hamm дунд сургууль, 4100 Vacation Lane

Ерөнхий зохицуулагчийг хайхтай холбоотой онлайн судалгааны маягтыг www.apsva.us/engage/search-for-new-aps-superintendent/ APS вэб сайтаас **1-р сарын 21-ээс 2-р сарын 2 хүртэл авах боломжтой**. Судалгааг хэзээ нээхийг танд мэдэгдэх зорилгоор School Talk мэдээг бид танд илгээнэ.

Та <https://www.apsva.us/engage/engage-aps-online-feedback/> вэб сайтаар дамжуулан онлайн маягт бөглөж эсвэл engage@apsva.us хаягаар имэйл илгээх замаар бичгээр санал бодлоо хэдийд ч илэрхийлж болно.

Энэ чухал даалгаврыг гүйцэтгэхэд үзүүлж буй таны тусламж дэмжлэгийг бид маш их үнэлж буй бөгөөд Арлингтоны улсын сургуулиудыг дэмжиж байгаад талархаж байна.

Хүндэтгэн ёсолсон,

Дарга Tannia Talento
Арлингтоны сургуулийн Удирдах Зөвлөлийн дарга